



ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

МОНГОЛБАНК

2021.10.26

Улаанбаатар хот

- I. МУЗГ, СЗХ-той хамтран хэрэгжүүлэх зорилт
- II. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл
- III. Эдийн засгийн төлөв, тооцоо судалгаа



ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2021 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

Улаанбаатар хот
2020 он



2020 МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН ЭРСДЭЛ БОЛОН ЭМЭЭГ БАЙДАЛ

Улаанбаатар хот
2020 он



Хайх

Ил тод байдал English Шелэн данс Нэвтр

Бндий тухай Мөнгөний бодлого Валютын зах Санхүүгийн тогтвортой байдал Төлбрийн систем Статистик Банкны хяналт шалгалт ОМА / МУТСТ

Мөнгөний бодлого

Мөнгөний бодлогын хороо

Мөнгөний бодлогын стратеги

Мөнгөний бодлогын хэрэгслүүд

Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэл

Инфляцын тайлан

Монголбанкны санал асуулга, судалгаа, хөтөлбөр

ОУВС-тай хамтран хэрэгжүүлсэн хөтөлбөр

НҮҮР / МӨНГӨНИЙ БОДЛОГО / ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Буца

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл

Монголбанкаас өргөн барьсан төслийг УИХ хэлэлцэж Төв банкнаас дараагийн жилд баримтлах үндсэн чиглэлийг УИХ-ы тогтоолын хавсралтаар баталдаг байна.

УИХ-аас батлагдсан мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн биелэлтийг Монголбанк УИХ-д улирал бүр тайлагнадаг байна.

ОН	Монголбанкны Ерөнхийлөгчийн хэлсэн үг	Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл	Үндсэн чиглэлийн төсөл /Өнөх оны хэрэгжилтийн хамт/
2022	-	-	2022 он
2021	Б.Лхагвасүрэн	УИХ-ын тогтоол	2021 он
2020	Н.Баярсайхан	УИХ-ын тогтоол	2020 он
2019	Н.Баярсайхан	УИХ-ын тогтоол	2019 он
2018	Н.Баярсайхан	УИХ-ын тогтоол	2018 он
2017	Н.Баярсайхан	УИХ-ын тогтоол	2017 он
2016	Н.Золжаргал	УИХ-ын тогтоол	2016 он
2015	Н.Золжаргал	УИХ-ын тогтоол	2015 он
2014	Н.Золжаргал	УИХ-ын тогтоол	2014 он
2013	Н.Золжаргал	УИХ-ын тогтоол	2013 он
2012	Л.Пүрэвдорж	УИХ-ын тогтоол	2012 он
2011	Л.Пүрэвдорж	УИХ-ын тогтоол	2011 он

МУИС-ийн номын санд



МӨНГӨ · САНХҮҮ · БАЯЛАГ

Эдийн засгийн судалгаа, шинжилгээний сэтгүүл
MONEY, FINANCE, WEALTH

2017/02 [2]

МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ

Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино. 2017-08-19-О



П-ЭРДЭНЭТУУЛ:
МОНГОЛБАНКНААС
"МОНГОЛ АЛ" АЯНЫГ
ЭХЛҮҮЛЭЭД БАЙНА

ЦИРКУЛЯР ЭДИЙН
ЗАСАГ /CIRCULAR
ECONOMY/
ТҮҮНИЙГ МОНГОЛД
НУТАГШУУВАА
АСУУДЛАУД

"Монгол Улсын Эрдэнэтийн сан" ивээлээр

Mongolbank @mongolbank www.mongolbank.mn Mongolbank



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МУЗГ, СЗХ-той хамтран хэрэгжүүлэх зорилтууд

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай (үргэлжлэл)

1/ Цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулж, эдийн засгийн сэргэлтийг дэмжих, өсөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөв, мөнгө, санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх;

2/ Уул уурхайн бус экспортыг дэмжих бодлогыг нэгтгэн тодорхойлж, санхүүгийн дэд бүтэц, санхүүжилтийн хүртээмжтэй тогтолцоог бүрдүүлэх, бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллах;

3/ Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 2023 оны харилцан үнэлгээнд бэлтгэх ажлын хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын Үндэсний хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, ФАТФ-ын зөвлөмжийн үнэлгээг дээшлүүлэх;

4/ Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлж эхлэх бэлтгэл ажлын хүрээнд Монголбанк хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт 2023 онд багтаан бүрэн шилжүүлэх, энэ хугацаанд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;



Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай (үргэлжлэл)

5/ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд гэрээний маргаан шийдвэрлэх үйл явцыг хялбаршуулах, зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх;

6/ Уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөг судалж, бүсийн болон олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, санаачилгатай уялдсан тогтвортой санхүүжилтийн бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэх;

7/ Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлын байрыг дэмжих зээл, хөдөө аж ахуйг дэмжих зээл, малчдыг дэмжих зээл, ипотекийн зээл, репо санхүүжилтийн зээл болон бусад төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хяналтыг үргэлжлүүлэх;



I. Улсын Их Хурлын тогтоолын төсөл

2.1. Цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулж, эдийн засгийн сэргэлтийг дэмжих, өсөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн мөнгө, санхүү, сангийн бодлогыг хэрэгжүүлэх

- ❖ Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт
 - Орлогын тэгш бус байдал
 - Боловсрол, эрүүл мэндийн чанар, хүртээмж
 - Тэгш боломж, оролцоо
- ❖ Төв банкны оролцоо
 - Макро эдийн засгийн тогтвортой байдал
 - ЭЗ-ийн уналт, хямралаас сэргийлэх
 - Бизнес, өрсөлдөөний тогтвортой орчин
 - Санхүүгийн хүртээмж
 - Хүн бүр хуримтлуулах, хөрөнгө оруулах
 - Бүтээмж, капиталын хуримтлалыг тэтгэнэ.
 - Бүтээмжтэй төсөл рүү нөөц хуваарилах



I. Улсын Их Хурлын тогтоолын төсөл

2.2. Уул уурхайн бус экспортыг дэмжих бодлогыг нэгтгэн тодорхойлж, санхүүгийн дэд бүтэц, санхүүжилтийн хүртээмжтэй тогтолцоог бүрдүүлэх, бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллах



УИХ-ЫН ТОГТООЛЫН 2.2-р заалт

Стратеги:

- Уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Төр – хувийн хэвшил, хувь-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өрнүүлэх, уялдааг хангах, мэдээллийг зөрүүг арилгах, төрийн зохицуулалтыг давхардлыг арилгах
- Ээлтэй санхүүгийн тогтолцоо: Санхүүжилт нөхцөл (хүү, хугацаа, барьцаа), даатгал, батлан даалт, төлбөр тооцоо
- Өмнөх болон шинээр боловсруулж буй бодлогын арга хэмжээний уялдааг хангаж, сайжруулалт хийх: 2018 оны “Монголын Экспорт” хөтөлбөрт, 2021 оны Их сэргэлтийн хууль гэх мэт
- Гадаад зах зээлийг нээх: Гадаад, дотоодын бизнесүүдийг уулзуулах, Шинэ зах зээл нээх, Протокол үйлдэх, Стандартыг оновчлох, Дотоодын стандартыг хөнгөвчилж нийцлийг хангах, Маркетинг-Брэндинг,
- Хүний нөөц, технологи, тээврийг сайжруулах: Тодорхой бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний бүлэг дээр суурилан тэдгээрийн экспортын маркетингийн чадавхи, зорилтот зах зээлд нэвтрэн орох боломж, экспортын хэмжээ зэрэгт тулгуурлан урт хугацааны бодлого, стратегитайгаар асуудалд хандах,
- Кластер байдлаар, өртгийн сүлжээ байдлаар нь бодлогыг тодорхойлж дэмжих



I. Улсын Их Хурлын тогтоолын төсөл

2.3. Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 2023 оны харилцан үнэлгээнд бэлтгэх ажлын хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын Үндэсний хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, ФАТФ-ын зөвлөмжийн үнэлгээг дээшлүүлэх



I. Улсын Их Хурлын тогтоолын төсөл

2.4. Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлж эхлэх бэлтгэл ажлын хүрээнд Монголбанк хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт **2023 онд багтаан бүрэн шилжүүлэх, энэ хугацаанд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх**



I. Улсын Их Хурлын ТОГТООЛЫН ТӨСӨЛ

2.5. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд гэрээний маргаан шийдвэрлэх үйл явцыг хялбаршуулах, зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх;

Гэрээний маргаан, чанаргүй авлагыг шуурхай барагдуулах чиглэлийн эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлнэ.

- Зээлийн хүүг бууруулахад хувь нэмэр болно
- Ковид-19 цар тахлын үед болон хожим нь чанаргүй зээл нэмэгдэх үед ач холбогдол илүү өндөр болно.

Банкны зээлийн хүүний бүтцийг авч үзвэл

- эх үүсвэрийн зардал 60 орчим хувь
- үйл ажиллагааны зардал 17 хувь
- зээлийн эрсдэлийн зардал 11 хувь
- банкны ашиг болон бусад зардал 12 хувийг тус тус эзэлж байна.






I. Улсын Их Хурлын тогтоолын төсөл

2.6. Уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөг судалж, бүсийн болон олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, санаачилгатай уялдсан тогтвортой санхүүжилтийн бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэх




УИХ-ЫН ТОГТООЛЫН 2.6-р заалтын үндэслэл

Уур амьсгалын өөрчлөлт ба Дэлхийн дулаарлын үр дагавар



Sources: Maddison Project Database 2018; Our World in Data 2020; and World Wildlife Fund Global Living Planet Index 2020.
Note: 2011 prices. PPP = purchasing power parity.

Манай улсад сүүлийн 10 жилд тохиолдсон цаг агаарын гаралтай гамшигт үзэгдлийн тоо 1990-ээд онтой харьцуулахад 3 дахин ихэссэн



Эх сурвалж: Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018 он

УИХ-ЫН ТОГТООЛЫН 2.6-р заалтын үндэслэл (үргэлжлэл)

ЭРСДЭЛ

Цаг уурын эрсдэл

- Бодит эрсдэл
- Шилжилтийн эрсдэл

Бизнес эрхлэгчид

- Бизнесийн тасалдал
- Үл хөдлөхийн эвдрэл
- Эрэлт ба зардлын өөрчлөлт

Өрх гэр

- Орлогын тасалдал
- Хэрэглэх хандлага өөрчлөгдөх
- Хөрөнгийн үнэ цэнэ буурах

ТӨВ БАНК

Шинэ эрсдэл

УАӨ нь эдийн засаг, санхүүгийн эрсдэлийн шинэ эх үүсвэр болж байна.

Макро үзүүлэлтэд нөлөөлж байна

- ЭЗ-ийн өсөлт
- Потенциал үйлдвэрлэл
- Үнийн ерөнхий түвшин

Мөнгөний бодлогын шилжих сувагт

- Хүүний суваг
- Зээлийн суваг
- Хүлээлтийн суваг
- Хөрөнгийн үнэ

АРГА ХЭМЖЭЭ

Улс орнуудын хамтын ажиллагаа өндөр түвшинд яригдаж байна.

Бодлого боловсруулагчид, зохицуулагч байгууллагууд УАӨ-ийг харгалзан үзэхийг шаардаж байна.

Олон улсын хамтын ажиллагааг өрнүүлэх, байгаль орчинд ээлтэй эх үүсвэрийн боломжийг ашиглахад зохицуулагч байгууллагаас дэмжих.

Тогтвортой санхүүжилтийн бодлого, стратегийн бодлого боловсруулагч, зохицуулагч байгууллагын түвшинд боловсруулж, хэрэгжүүлж эхлэх.

Төв банк, санхүүгийн зохицуулагч байгууллагууд нийт системийн түвшинд нөлөөлж буй цаг уурын болон байгаль орчны эрсдэлийг бууруулах,

I. Улсын Их Хурлын тогтоолын төсөл

2.7. Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлын байрыг дэмжих зээл, хөдөө аж ахуйг дэмжих зээл, малчдыг дэмжих зээл, ипотекийн зээл, репо санхүүжилтийн зээл болон бусад төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хяналтыг үргэлжлүүлэх



II. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ



Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2022-2024 онд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулна. Инфляцыг тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогын шийдвэрийг гаргахдаа зах зээлийн зарчимд тулгуурлан нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлтийн шууд бус нөлөөг нягтлан үзэж, эдийн засгийн сэргэлтийг удаашруулахгүй байх зарчмыг баримтлана.

1.2. Ковид-19 цар тахлын хүндрэлийг даван туулах, эдийн засгийн сэргэлт, дунд хугацааны макро тогтвортой байдлыг дэмжсэн зээлийн тогтвортой өсөлтийг хангаж, банкны системд эрсдэл хуримтлагдахаас сэргийлсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

1.3. Төв банкны олон нийттэй харилцах харилцааг хөгжүүлж, бодлогын ил тод байдлыг хадгалж ажиллана.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл (үргэлжлэл)

Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд:

2.1. Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын стандартад нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлж, цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хүрээнд мөрдөгдөж буй зохицуулалтыг ердийн нөхцөлд шилжүүлэх төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.2. Банк хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулах хууль, эрх зүйн шаардлагын хүрээнд хяналт шалгалт, зохицуулалтыг боловсронгуй болгож мөрдүүлнэ.

2.3. Банкны салбарын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгаа, үр дүнд үндэслэн эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдлийг арилгаж нэгдмэл байдлыг хангах, зээлийн мэдээлэл, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, буцаан худалдан авах барьцаат санхүүжилтийн хэлцлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээ авна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл (үргэлжлэл)

Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1. Төв банкны цахим мөнгө гаргах талаар судалж, хөгжүүлнэ.

3.2. Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар шинэ технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг дэмжиж, төлбөрийн систем дэх хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дэмжинэ.

3.4. Макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн шинжилгээнд их өгөгдлийг ашиглах техникийн болон мэргэшлийн ур чадварыг үе шаттайгаар бүрдүүлж эхлэнэ.

III. ТӨСЛИЙН ТООЦОО, СУДАЛГАА: ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ



Цар тахлын сөрөг нөлөөний сувгууд

- Эдийн засгийн бус шалтгаан: Нийтийн эрүүл мэндийн хямрал
- Санхүүгийн захын зогсонги байдал: Санхүүгийн нөхцөл чангарах
- Санхүүгийн эрсдэл, дефолт: Өрх, ААН, Санхүүгийн байгууллага
- Хүлээлт муудах
- Идэвхжил vs Эрүүл мэнд
- Төсөөлөл, таамаглах бололцоо хязгаарлагдмал
- Эдийн засгийн салбаруудад үзүүлэх нөлөө харилцан адилгүй: **Тэгш бус байдал гүнзгийрэх**
 - Орлогын тэгш бус байдал
 - Боломжийн тэгш бус байдал: Боловсол, эрүүл мэндийн тэгш бус байдал
 - Амьдрах орын тэгш бус байдал
 - Бүс нутаг хоорондын ялгаатай байдал
 - Үе хоорондын тэгш бус байдал: өрийн асуудал



Цар тахлын үед Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн арга ХЭМЖЭЭ

2020.03.11

Бодлогын хүү
↓ 1 нэгж хувь

Төгрөгийн ЗБН-ийн хувь хэмжээ
↓ 2 нэгж хувь



2020.04.13

Бодлогын хүү
↓ 1 нэгж хувь



2020.08.07

Зээлийн бүтцийн өөрчлөлтийн хэрэгжих хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгав



2020.09.14

Бодлогын хүү
↓ 1 нэгж хувь

Урт хугацаат санхүүжилтийн хэрэгсэл нэвтрүүлэв



2020.11.23

- Бодлогын хүү 2 нэгж хувь ↓
- Төгрөгийн ЗБН-ийн хувь хэмжээ 2.5 нэгж хувь ↓
- Урт хугацаат санхүүжилт, Зээлийн бүтцийн өөрчлөлт



2021.09.16

- Бодлогын хүүг хэвээр байлгах
- Урт хугацаат санхүүжилтийн хэрэгсэл: 2021Q3 - 100 тэрбум төгрөг хүртэл
- Хэрэглээний зээлийн өр, орлогын харьцаа тооцох аргачлалд өөрчлөлт оруулах

2020.12.18

Урт хугацаат санхүүжилтийн хэрэгсэл: 2021Q1 - 250 тэрбум төгрөг хүртэл



2021.03.24

- Урт хугацаат санхүүжилтийн хэрэгсэл:
- Репо хүүг 0.5 нэгж хувиар бууруулах
 - 350 тэрбум төгрөг хүртэл.
 - Боловсруулах, үйлчилгээ болон 200-аас дээш ажиллагчидтай худалдааны салбарын ААН-үүдийг хамруулах



2021.06.23


Урт хугацаат санхүүжилтийн хэрэгсэл: 2021Q2 - 250 тэрбум төгрөг хүртэл




Цар тахлын нөлөө: Инфляц, ЭЗӨ

Сонгогдсон улсуудын инфляцын динамик

- Дэлхий нийтээр үнийн өсөлт эрчимжиж байна



Дэлхийн нийтээр инфляц өсч Төв банкуудын зорилтоос давж байна




Эдийн засгийн өсөлт, түүний төсөөлөл

- 2020 оны эдийн засгийн уналт Австри, Сингапур, Словак, Япон, Малайз, Чех, Чили, Канад, Тайланд зэрэг орнуудтай ойролцоо байна.
- Латин Америк, Евро бүс, Өмнөд Ази цар тахалд хамгийн их өртжээ.
- Сүүлийн 80 жилд хямралын дараа глобал эдийн засаг хамгийн хурдтай сэргэж байна

	2019	2020	2021*
Дэлхий	2.5	-3.6	5.6
Хөгжсөн орнууд	1.6	-4.7	5.4
АНУ	2.2	-3.5	6.8
Евро бүс	1.3	-6.6	4.2
Япон	0.0	-4.7	2.9
Хөгжиж буй орнууд	3.8	-1.7	6.0
Зүүн Ази, Номхон далайн орнууд	5.8	1.2	7.7
Европ, Төв Ази	2.7	-2.1	3.9
Латин Америк, Карибын тэнгис	0.9	-6.5	5.2
Хойд Америк, Дундад Ази	0.6	-3.9	2.4
Өмнөд Ази	4.4	-5.4	6.8
Саб-Сахарын Африк	2.5	-2.4	2.8
Түүхий эд импортлогч хөгжиж буй орнууд	4.9	-0.6	7.3
Хятадаас бусад түүхий эд импортлогч	3.2	-4.7	5.4
Түүхий эд экспортлогч хөгжиж буй орнууд	1.8	-4.0	3.6
Монгол**	5.1	-4.6	5.1

Эх сурвалж: Дэлхийн банк, **Монголбанк

Инфляц 2021 оны 8-р сард



Хүнсний бус бүлэг



Шатахуун

37.9%



Хатуу түлш

17.0%



Импортын
бараа

5.4%



Бусад дотоодын
бараа,
үйлчилгээ

5.8%

Хүнсний бүлэг



Мах

15.1%



Сүү, сүүн
бүтээгдэх
үүн

9.3%



Талх,
гурил,
будaa

6.8%



Хүнсний
ногоо

20.3%



Жимс,
жимсгэнэ


30.3%




Тос

23.7%


Инфляц: Хүнс, Хүнсний бус



Нийлүүлэлтийн болон нэг удаагийн хүчин зүйлс голлон үнийн өсөлтийг тайлбарлаж байна.



Жилийн инфляц нийслэлд 3-р сараас 8-р сард 7.1 нэгж хувиар өсөхөд (хаалтад үзүүлэх нэгж хувийг) оруулав):



Улаанбаатар хотын жилийн инфляцад голлон нөлөөлсөн бараа, бүтээгдэхүүнүүд:



	Нэр (Жин)	Жилийн өсөлт			Жилийн инфляцад эзлэх хувь		
		3 сар	7 сар	8 сар	3 сар	7 сар	8 сар
Шатахуун	(0.06)	-16.2%	38.1%	37.9%	-0.9%	1.7%	1.7% (≈)
Мах	(0.10)	8.3%	15.8%	15.1%	0.9%	1.8%	1.6% (↓)
Хатуу түлш	(0.03)	-26.6%	11.6%	17.0%	-1.3%	0.5%	0.8% (↑)
Нийтийн хоолны үйлчилгээ	(0.04)	8.6%	14.1%	15.6%	0.4%	0.6%	0.7% (↑)
Автомашин	(0.04)	5.5%	12.8%	16.3%	0.2%	0.5%	0.6% (↑)
Хүнсний ногоо	(0.04)	9.5%	-3.6%	20.3%	0.2%	-0.1%	0.5% (↑)
Нийлбэр	(0.31)					5.5%	5.9%

Инфляц: Жилийн дүнгээр хамгийн ихээр үнэ өссөн барааны жагсаалт /8-р сар, 20%-иас дээш өсөлттэй/

	Хэрэглээний сагсан дах бүтээгдэхүүн	жин	Жилийн өсөлт	Жилийн инфляцад үзүүлэх нөлөө
1	Сонгино, кг, БНХАУ	0.3%	77.6%	0.2%
2	Ханын цаас, рулонтой, угаадаг, саа болон товгор хээгүй, БНСУ	0.2%	56.8%	0.1%
3	Жолооны курсын төлбөр, "В" ангилал	0.1%	52.3%	0.0%
4	Гурвалжин будаа, 650 гр, импортын	0.0%	49.4%	0.0%
5	Лууван, кг,	0.3%	48.4%	0.2%
6	Хүрэн манжин, кг, дотоод	0.1%	48.0%	0.0%
7	Бензин, А-80, 1 литр	2.4%	47.4%	0.8%
8	Мандарин, кг, импортын	0.1%	46.1%	0.0%
9	Бензин, А-92, 1 литр	1.8%	45.8%	0.6%
10	Байцаа, кг, импортын	0.2%	45.4%	0.1%
11	Ачаа тээвэр, хот дотор, 15 км, 1 тн	0.0%	42.9%	0.0%
12	Улаан лооль, бөөрөнхий, кг, импортын	0.1%	40.9%	0.0%
13	Түлшний мод, шуудайгаар	0.9%	40.7%	0.8%
14	Алим, шар, кг, импортын	0.5%	37.9%	0.2%
15	Усан үзэм, кг, хүрэн, БНХАУ	0.0%	37.5%	0.0%
16	Харандаа, 0.5мм, БНХАУ	0.0%	33.3%	0.0%
17	Ургамлын тос, 1 л, импортын	0.3%	32.7%	0.1%
18	Даралтны эм	0.2%	32.2%	0.1%
19	Шар тос, дотоодын	0.0%	31.8%	0.0%
20	Дотор мах, цувдай, цусгүй	0.2%	31.3%	0.1%
21	Кетчуп, 900 гр, "Чили", 900 гр, Польш	0.0%	29.4%	0.0%
22	Бугуйн цаг, эмэгтэй хүний, дугуй хэлбэрийн, диаметр 2.5 см, хиймэл ширэн оосортой	0.0%	29.0%	0.0%
23	Сүү, үнээний, задгай, л	0.7%	26.8%	0.2%
24	Параденк, хүүхдийн лаа	0.1%	26.8%	0.0%

	Хэрэглээний сагсан дах бүтээгдэхүүн	жин	Жилийн өсөлт	Жилийн инфляцад үзүүлэх нөлөө
25	Хөлдөөсөн бууз, савласан, дотоодын үйлдвэрийн	0.6%	24.4%	0.1%
26	Зочид буудлын хөлс, энгийн, 1 хүн, 1 хоног	0.0%	24.2%	0.0%
27	Амтат чинжүү, кг, импортын	0.1%	24.1%	0.0%
28	Хорхой ааруул, задгай, чихэртэй, кг	0.1%	23.1%	0.0%
29	Аймгаас -УБ орох автобусны /тендер/ хөлс, нэг талдаа	0.1%	23.0%	0.0%
30	Хурууны лент, 1ш, БНХАУ	0.0%	22.7%	0.0%
31	Жимсний шүүс, "Монфреш", алимны, 1 л	0.3%	22.6%	0.1%
32	Цөцгийн тос, цаасан боолттой, 200 гр, дотоодын үйлдвэрийн	0.4%	22.4%	0.1%
33	Гуанзны хоолны үнэ, /цуйван, сүүтэй цай/, аймгийн төв захын гуанз	2.1%	22.3%	0.5%
34	Дизелийн түлш, 1 литр	1.7%	21.7%	0.3%
35	Оршуулгын машин түрээслэх хөлс	0.2%	21.2%	0.0%
36	Хоол амтлагч, "Дашида" 50 гр, БНСУ	0.1%	21.2%	0.0%
37	Гурил исгэгч, 12 гр, "Данбаоли", БНХАУ	0.0%	20.3%	0.0%
38	Цахилгааны разетка солиулах ажлын хөлс	0.1%	20.1%	0.0%
39	Витамин "С", үрлэн, 50ш	0.2%	20.0%	0.0%
	Дотоодын бараа	6.7%		2.3%
	Импортын бараа	8.2%		2.6%
	Нийлбэр	14.9%		4.8%

Дотоод эдийн засаг сэргэж, инфляц нэмэгдэх хандлагатай боллоо.



Инфляц сэргэлттэй уялдан алгуур нэмэгдэх хэдий ч нийлүүлэлтийн хүчтэй байна.


- Нийлүүлэлтийн шалтгаантайгаар инфляц нэмэгдэж байна.
- Дотоод эрэлт сэргэж эрэлтийн шинжтэй инфляцыг алгуур өсгөхөөр байна.
- Дунд хугацаанд инфляц Төв банкны зорилтын орчимд тогтворжих хүлээлт хэвээр байна.

Инфляц 8-р сард улсын хэмжээнд 8.9 хувь, Улаанбаатарт 9.1 хувь байв.

- Шатахууны үнэ 7-р сард огцом нэмэгдсэнээр инфляцын 1.7 нэгж хувийг тайлбарлав.
- Махны үнэ жилийн 15.1 хувиар өсч инфляцыг 1.6 нэгж хувиар нэмэгдүүлэв.
- Хатуу түлш 17%-иар өсч, 0.8 нэгж хувиар нэмэгдүүлэв.
- Нийтийн хоолны үйлчилгээний үнэ жилийн 15.6 хувиар өсч инфляцыг 0.7 нэгж хувиар нэмэгдүүлэв.

Инфляц 2022 оны сүүлийн хагаст Төв банкны зорилтот түвшин (6%)-д тогтворжих хүлээлттэй.

Инфляц болон эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эдийн засгийн өсөлт 2022 онд 5.9% голчтой, 30% итгэх интервал 3.7%-8.0%.

- Ирэх онд цар тахалтай холбоотой уналтаас гарч уул уурхайн бус ихэнх салбар хэвийн түвшиндээ хүрэх хүлээлттэй байна.

ЗДотоод эрэлт сэргэж, эдийн засгийн өсөлтийг тэтгэнэ.

- Цар тахал, түүхий эдийн үнээс өсөлт ихээхэн хамааралтай.


Энэ оны эхний хагаст ЭЗӨ 6.3%.

- Уул уурайн салбар 24.3 хувиар өсч,
- Уул уурхайн бус салбар 4 хувиар өсч, 3.6 нэгж хувийн эерэг нөлөөтэй байв.



УУ салбарын -14.9% уналтанд:

- Нүүрс -11.4 нэгж хувь (-54.1%)
- Төмрийн хүдэр -1.9 нэгж хувь (-14.5%)
- Газрын тос -1.3 нэгж хувь (-18.2%)
- Зэсийн баяжмал +4.4 нэгж хувь (+12.6%)
 - Эрдэнэт -1.2 нэгж хувь (-8.1%)
 - ОТ +5.6 нэгж хувь (+27.6%), агууламж 2.9 дахин нэмэгдсэн
- Алт -4.7 нэгж хувь (-20.2%)

*4 улирлын нийлбэр ДНБ-ий өсөлт



Бодит ДНБ-ий төсөөллүүд



- Дэлхий нийтэд Ковид-19 вирус тархан, 2020 онд дотооддоо тодорхой хөл хорионы дэглэмийг хэрэгжүүлсэн нь бодит ДНБ-ийг 1 жилээр ухраажээ
- 2020 оны 4 дүгээр улирлаас Ковид-19 вирус дотооддоо тархсан нь мөн бодит ДНБ-ийг 1 жилээр ухраасан байна
- Уул уурхайн бус салбарын ДНБ-ий түвшинг Ковид-19 вирусийн тархалт мөн 1-1.5 жилээр ухраасан байна.
- Уул уурхайн бус ДНБ 20Q4, 21Q1 төсөөллөөс сайжирсан, 21Q2 төсөөллөөс өөрчлөлтгүй.

Борлуулалтын орлого өссөн байна.

Салбар	2019.06	2020.06	2021.06	2021.06/ 2020.06 өөрчлөлт	2021.06/ 2019.06 өөрчлөлт
	тэрбум төгрөг				
Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалт	10,612	7,465	12,088	61.9%	13.9%
Уул уурхай, олборлолт	7,140	4,596	8546	86.0%	19.7%
Боловсруулах	2,515	2,164	2754	27.3%	9.5%
Цахилгаан, дулаан	957	706	788	11.7%	-17.7%
Худалдаа	10,789	9,810	11,891	21.2%	10.2%
Төмөр замын тээвэр	336	366	393	7.3%	16.9%
Агаарын тээвэр	209	87	72	-16.7%	-65.4%





2021 оны 3.10-ны өдрөөс 10-р сарын 7-ны өдрийн байдлаар

АБДЗ

/нийт олгосон зээл/

1,886

тэрбум ₮

24,731

зээлдэгч

РЕПО

/нийт олгосон зээл/

726

тэрбум төг

3,109

зээлдэгч

Ипотек

/нийт олгосон зээл/

817


тэрбум төг

10,839


зээлдэгч

Банкны системийн зээлийн өсөлт болон зээлийн хүү

Зээлийн жилийн өсөлт, зориулалтаар




Шинээр олгосон зээлийн хүү (₮)




- “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилттэй холбоотойгоор зээлийн өсөлт сэргэж байна.
- 10 их наядын цогц төлөвлөгөөний хөнгөлөлттэй зээлүүдийн нөлөөгөөр банкны системийн нийт зээлийн хүү (хөнгөлөлттэй зээлүүдийг оруулсан) энэ 1 дүгээр улирлаас эхлэн буурч **11-13** хувийн орчимд байна.
- Харин хөнгөлөлттэй зээлүүдийг хасч тооцвол зээлийн хүү 2021 оны 7 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар буурч 14.6 хувьд хүрсэн нь түүхэн доод түвшин юм.

Төлбөрийн тэнцэл 2021 онд 370 сая \$-ын алдагдалтай байх хүлээлттэй.

Төлбөрийн тэнцлийн төсөөлөл



Урсгал данс/ДНБ-д эзлэх хувь



Ирэх онуудад барааны тэнцэл харьцангуй нам, тогтвортой байх төсөөлөлтэй байна.

- Барааны тэнцэл бага хэдий ч орлого, үйлчилгээний дансны алдагдал өндөр байж, улмаар урсгал дансны алдагдал нэрлэсэн ДНБ-ий 15 хувийг давахаар байна.

ГШХО-н өсөлтөөс шалтгаалж хөрөнгө, санхүүгийн дансны ашиг нэмэгдэх хүлээлттэй байна.

- ОТ болон бусад гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэхээр байгаа нь хөрөнгө, санхүүгийн дансны ихэнх хэсгийг тайлбарлахаар байна.

Нийт төлбөрийн тэнцэл 2021 онд алдагдалтай байх хэдий ч ирэх онуудад ашигтай байхаар байна.

Эдийн засгийн сэргэлт үргэлжилж байгаа боловч гадаад секторын сөрөг нөлөө нэмэгдэх хандлагатай болж байна...

- Эдийн засаг сэргэж байгаа ч энэ оны төсөөллийг бага хэмжээгээр бууруулав.
 - УУЛ уурхай: Нүүрс, зэсийн агууламж буурсан.
 - Уул уурхайн бус: Тээвэр, барилга, ХАА, Боловсруулах, үйлчилгээ хүлээлтэд хүрээгүй.
 - УУБ салбарын өсөлт оны сүүлийн хагаст идэвхжил нэмэгдэх хүлээлт хэвээр байна.
 - Ковид-19 вирусын эдийн засагт үзүүлэх нөлөө нэмэгдэж, үргэлжлэх хугацаа нь сунжирч байна. Төсөөллийн гол тодорхой бус байдал өндөр байна.
 - Инфляц нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлээс хамааран богино хугацаанд өсөх эрсдэлтэй байна.
- Ковид-19 цар тахалтай холбоотойгоор санхүүгийн зах зээлд тодорхой бус байдал өндөр хэвээр байна.
 - Эх үүсвэрийн долларжилт буурав.
 - 10 их наядын цогц төлөвлөгөө үүргээ гүйцэтгэж, зээлийн өсөлтийг тэтгэв. Цаашид гадаад, дотоод макро тэнцвэрийг харгалзан эрсдэлийг тооцох шаардлагатай.
 - Цар тахалтай холбоотойгоор зээлийн чанар муудах, харьцаа үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлж зээлийн төлөвт нөлөөлөх эрсдэлтэй байна.
- Гадаад орчны тодорхой бус байдал өндөр байна.
 - Ковид-19-ын мутацид орсон вирусын давалгаа улс орнуудад дэгдэх нь гадаад, дотоод эрэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.
 - Тээвэр, логистикийн түгжрэл
 - манай хилийн бүс дэх хязгаарлалт
 - Дэлхийн нийтийн тээврийн ачаалал нэмэгдсэн
 - Дэлхийн болон манай тээврийн зардал өссөн
 - Хэвийн горимд орох хугацаа дэлхий нийтэд тодорхойгүй байна.
 - Урсгал тэнцлийн алдагдал өндөр тул гадаад тэнцэл зээл, тусламжаас их хамааралтай байна.
- Сангийн болон мөнгөний бодлогын орон зай нь төлбөрийн тэнцлээс хамаарна.
 - Нүүрсний экспортыг бууруулсан
 - Импортын өсөлт хүлээлтээс давсан
 - ГШХО хүлээлтээс муудах мэдээлэл байхгүй байна
 - Экспортын бууралттай холбоотой Урсгал тэнцлийн алдагдал/ДНБ харьцаа муудсан
- Мөнгөний бодлого: Бодлогын сорилт
 - ДНБ-ий сөрөг зөрүү vs Инфляцын хүлээлт vs Credibility



Анхаарал хандуулсанд баярлалаа!

Вебсайт: www.mongolbank.mn



@mongolbank_mn



@mongolbank.mn



mongolbank